

ОРОН НУТГИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН БАГШИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ, ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Э.Боролдой Б.Цог
E.Boroldoi@dornod.edu.mn
Дорнод их сургууль

Хураангуй

Байгууллага аж ахуйн нэгжийн удирдлагууд өрсөлдөх чадвар, бүтээмж, үр ашгаа өсгөхийн тулд тоног төхөөрөмжөө сольж технологийн шинэчлэлт хийхийг чухалчилж үздэг байсан нь хоцрогдож, хүний нөөцийн менежментийн чухал асуудлын нэг болох ажлын сэтгэл ханамжид анхаарлаа хандуулах нь их болжээ.

Боловсролын салбар нь үйлчилгээний салбар болохын хувьд тоо хэмжээгээр бус ихэвчлэн чанар, үр дүнгээр бүтээмжийг тодорхойлно. Дээд боловсролын байгууллагын чанар, хүртээмжийг оролцогч талуудын сэтгэл ханамжийн түвшин, сэтгэл ханамжид нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох судалгааг хийлээ. Судалгааны явцад 5 төрлийн таамаглал дэвшүүлсэний дөрөв нь батлагдсан үр дүн гарав.

Түлхүүр үг: байгууллагын үнэт зүйлс, багш, сэтгэл ханамж, нөлөөлөл

Үндэслэл: Компанийн амжилтын үндэс бол ажлын төлөө сэтгэлтэй, чадварлаг, идэвхи зүтгэлтэй ажилтан бөгөөд байгууллагадаа баялгийг бий болгож, хөгжлийг авчирдаг гол хүчин зүйл үнэт зүйлсийн нэг нь ажилчид юм (Статут, 2009).

Боловсролын салбар нь үйлчилгээний салбар болохын хувьд тоо хэмжээгээр бус ихэвчлэн чанар, хүртээмжээр үр дүнг бүтээмжийг тодорхойлно. Дээд боловсролын байгууллагын чанар, хүртээмжийн хэмжүүр нь оролцогч талуудын сэтгэл ханамжаар илэрнэ.

Их дээд сургуулиуд оюутан, төгсөгч, ажил олгогч талын сэтгэл ханамжийн судалгааг янз бүрийн давтамжтай хийдэг ч багш нарын сэтгэл ханамжийн судалгааг орхигдуулах хандлага ажиглагддаг учраас энэхүү судалгааг хийлээ.

Зорилго: Орон нутгийн их дээд сургуулийн багш нарын сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийг илрүүлэх, сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох

Зорилт: Судалгаанд багш нарын сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийг илрүүлэхдээ насны хамааралтай эсэх, ажиллах орчин, байгууллагын ажилтнуудын хоорондын харилцаа, Байгууллагын удирдлагын үр чадвар, цалин хөлс болон нөхөн олговор нь багшийн сэтгэл ханамжид хэрхэн нөлөөлдөг эсэхийг тодруулах зорилт тавилаа.

Судалгааны арга зүй: Орон нутгийн их, дээд сургуулийн нийт 44 багшийн оролцогчийн анкетыг программд оруулж үр дүнг оруулсан болно.

Судалгаанд баримт бичиг, асуулгын аргуудаар Үндсэн 9 бүлгийн 43 асуулт боловсруулан 1-6 хуваарь бүхий Ликертийн схемийг (likert scale) ашиглан сэтгэл ханамжийн түвшинг тодорхойллоо. Судалгааны үр дүнг боловсруулахдаа SPSS 23, EXCEL 2019 програмыг ашигласан болно.

Cronbach's alpha шинжилгээ
/асуулгын найдвартай байдлын шинжилгээ/

Хүснэгт 1. Асуултын найдвартай байдлын шинжилгээ SPSS 23 /cronbach alpha/

Reliability Statistics		
Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.965	.962	51

Асуултын найдвартай байдал 95% байна. Энэ үр дүн нь асуулт өндөр түвшинд найдвартай байгааг харуулж байна.

Судалгааны үр дүн: Судалгаанд 44 анкетыг программд оруулж, сэтгэл ханамжийн түвшинг 1-6 хүртэлх шкалаар үнэлсэн. Судалгаанд 75 % эмэгтэй, 25% эрэгтэй оролцогчид эзэлж байна.

1.1. Нэг хувьсагчийн шинжилгээний үр дүн

Хүснэгт 2. Сэтгэл ханамжийн бүлэг асуулт / ерөнхий дундаж түвшин/

Бүлэг	Сэтгэл ханамжийн түвшин
Байгууллагын дотоод үйл ажиллагаа	3.16
Ажлын байрны орчин	3.29
Харилцаа	3.48
Суралцаж хөгжих боломж	3.12
Дэвших боломж	3.04
Удирдах үр чадвар /удирдах албан тушаалтан/	2.83
Цалин хөлс болон нөхөн олговор	3.04
Үйл ажиллагааны үнэлгээ хяналт	2.67
Мэргэжил болон хийж байгаа ажил	4.16
Ерөнхий сэтгэл ханамж	3.20

Судалгааны үр дүнгээс харахад багш нарын сэтгэл ханамжийн ерөнхий түвшин 3.2 буюу сэтгэл ханамжгүй гэсэн үнэлгээг авчээ. Энэ сэтгэл ханамжийн түвшин дунджаас доогуур үзүүлэлт гарсан ба бүлэг тус бүрээр авч үзэхэд хамгийн өндөр түвшинг “мэргэжил болон хийж байгаа ажил” 4.16 буюу сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээг өгсөн. Хамгийн бага түвшинг “үйл ажиллагааны үнэлгээ хяналт” 2.67 буюу их сэтгэл ханамжгүй гэсэн дундаж утгатай байна.

1.2. Хоёр хувьсагчийн тархалтын шинжилгээ

Судалгаанд оролцогчдын 57.1 % нь ажилчдын харилцаанд сэтгэл ханамжтай буюу 3 гэсэн үнэлгээ өгсөн ба Багш ажилчдын хоорондын харилцааг сайжруулснаар нийт ажилтнуудын 60% нийт сэтгэл ханамж их, Хи квадратын аргаар $P\text{ value}=0.021$ байгаа нь багш ажилтнуудын харилцаа, нийт сэтгэл ханамж нь хоорондоо хамааралтай байна. 41.7% нь ажлын байрны орчинд сэтгэл ханамжтай буюу 3 гэсэн үнэлгээ өгсөн үед ба $P\text{ value}=0.011$ байгаа нь ажлын байрны орчин, ажлын сэтгэл ханамж нь хоорондоо мэдэгдэхүйц хамааралтай байна.

Судалгаанд оролцогчдын 50% нь байгууллагын даргын харилцааны ёс зүйд сэтгэл ханамжтай 3 гэсэн үнэлгээ өгсөн ба $P\text{ value}=0.001$ байгаа нь шууд хамааралтай байна. 54.5% нь ажил үүргээр тодорхой хангадаг байдалд сэтгэл ханамжтай 3 гэсэн үнэлгээ өгсөн ба $P\text{ value}=0.018$ байгаа нь ажлын байрны орчин, ажлын сэтгэл ханамж нь хоорондоо мэдэгдэхүйц хамааралтай байна.

Судалгаанд оролцогчдын 42% нь цалин хөлс болон нөхөн олговорт сэтгэл ханамжтай буюу 4 гэсэн үнэлгээ өгсөн ба Хи квадратын аргаар $X^2 = 151.24$ ба $P\text{ value}=0.018 < 0.05$ байгаа нь цалин хөлс болон нөхөн олговор, ажлын сэтгэл ханамж нь хоорондоо мэдэгдэхүйц хамааралтай байна.

Хүснэгт 3. Ажлын сэтгэл ханамжид нөлөөлж буй олон хүчин зүйлсийн хамаарал (Корреляцийн шинжилгээний дүн)

	Байгууллагын дотоод үйл ажиллагаа	Ажлын байрны орчин	Суралцаж хөгжих боломж	Дэвших боломж	Удирдах үр чавдар / удирдлага/	Цалин хөлс болон нөхөн олговор	Үйл ажиллагааны үнэлгээ хяналт	Сэтгэл ханамж
Байгууллагын дотоод үйл ажиллагаа	1							
Ажлын байрны орчин	.654**	1						
Суралцаж хөгжих боломж	.417**	.610**	1					
Дэвших боломж	.612**	.572**	.662**	1				
Удирдах үр чавдар / удирдах албан тушаалтан/	.769**	.668**	.522**	.604**	1			
Цалин хөлс болон нөхөн олговор	.613**	.663**	.562**	.634**	.665**	1		
Үйл ажиллагааны үнэлгээ хяналт	.543**	.655**	.466**	.557**	.598**	.776**	1	
Сэтгэл ханамж	.448**	.659**	.643**	.558**	.406**	.625**	.350*	1

Багш нарын ажлын сэтгэл ханамжид нас хамааралгүй, ажилчдын хоорондын харилцаа, орчин, ажилүүргийн тодорхой байдал хамааралтай байгаа нь Хи квадратын шинжилгээнээс харагдаж байгаа бөгөөд уг хамаарлын хүчийг Пирсоны коррелляциар судлан үзэхэд үйл ажиллагааны хяналт, цалин олговор хооронд 0.776 ажлын байрны орчин, ажлын сэтгэл ханамж хооронд 0.659 , цалин хөлс нөхөн олговор, ажлын сэтгэл ханамж хооронд 0.625 буюу тус тус хүчтэй хамааралтай байна.

Хүснэгт 4. Ажлын чиг баримжаа олгох асуулт

	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Дэвших боломж
Би мэргэжлийнхээ дагуу ажилладаг	82.8	13.8	3.4	
Би цаашид энэ ажлаа үргэлжлүүлэн хийнэ	51.7	6.9	41.4	
Би өөрийнхөө ажлын хэрхэн яаж гүйцэтгэхээ сайн мэддэг	89.3		10.7	
Би идэвхи зүтгэлтэй санаачлагатай ажилладаг	82.1	10.7	7.1	1
Би өөрийнхөө бүхий л нөөц бололцоог дайчлан ажилладаг	85.7	10.7	3.6	.604**

Судалгаанд оролцогчдын 82.8 % нь өөрийн мэргэжлийнхээ дагуу ажилладаг байна. Харин 17.2% нь үгүй, мэдэхгүй гэж хариулсан нь багш нарын А цагийн ачаалалтай холбоотой буюу нэг багш дундажаар 5-9 төрлийн хичээл ордогтой холбоотой. 41.4% нь цаашид энэ ажлаа үргэлжлүүлэн хийх талаар мэдэхгүй буюу маш их эргэлзсэн хариултыг өгсөн байна. Энэ нь судалгаанд оролцогчдын ерөнхий сэтгэл ханамж муу гарсантай хамааралтай. 89.3% нь өөрийн ажил мэргэжлийн гүйцэтгэх үүргээ сайн мэддэг байна.

Нээлттэй асуултын үр дүн Таны зүгээс ажлынхаа юунд нь сэтгэл хангалуун байдаг эсэх асуултанд Хамт олны уур амьсгал, харилцаа, оюутнуудтай ажиллаж байгаад, мэргэжилдээ дуртай, ажлын нэр хүнд сэтгэл хангалуун байдаг гэсэн хариултыг өгсөн байна. Ажилдаа сэтгэл ханамжтай байхад хамгийн чухал нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлсийг нэрлэхэд Ажлын байрны орчин, хамт олны уур амьсгал, харилцаа, оюутнуудтай ажиллах, өөрийгөө хөгжүүлэх боломж, цалингийн тогтолцоо сэтгэл ханамжтай байхад нөлөө үзүүлдэг гэсэн байхад ажилдаа сэтгэл ханамжгүй байхад нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлсэд ажлын ачаалал, тодорхойгүй төлөвлөөгүй ажил үүрэг, цалин хөлс урамшуулал, ажил мэргэжлийн уялдаа холбоогүй ажил үүрэг, хүний нөөцийн тогтворгүй байдал, бүтэц зохион байгуулалт, шударга бус байдал нөлөө үзүүлдэг байна. Ажлаа сайн гүйцэтгэхийн тулд байгууллагын зүгээс юуг өөрчлөн, сайжруулах шаардлагатай гэсэн асуултанд Ажлын ачаалалыг

тэнцвэржүүлэх, байгууллагын бүтэц орон тоог батлах, гадаад дотоодыг байгууллагатай хамтран ажиллах, эрдэм шинжилгээний бааз бий хийх, төлөвлөлтийг нарийн хийх, удирдлагаар хангах, ажлын гүйцэтгэлийн үр дүнг хэмждэг үнэлдэг байх, цалин хөлсний тогтолцоог сайжруулах нь хэрэгтэй гэсэн хариулт өгсөн байна.

Дүгнэлт: Судалгааны үр дүнгээс харахад багш нарын сэтгэл ханамжийн ерөнхий түвшин 3.2 буюу сэтгэл ханамжгүй үзүүлэлттэй байгаа нь байгууллага багш нарын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж тайлагнах, үр дүнг сайжруулах шаардлагатай байна.

Судалгаанд оролцогчдын сэтгэл ханамжтай байдлыг жигнэсэн дундаж утгаар тооцоолж үзэхэд мэргэжил болон хийж байгаа ажилд сэтгэл ханамжтай байгаа бол, үйл ажиллагааны үнэлгээ хяналт, удирдах ур чадвар, цалин хөлс болон нөхөн олговорт сэтгэл ханамжгүй байна.

Өөрийн мэргэжил, тус байгууллагад ажиллаж байгаадаа, оюутнуудтай ажиллах харилцах, бүх тэтгэмж цалин хугацаандаа олгодог байдал, багш ажилчдын дотоод уур амьсгал, сургалтад хамрагдах байдал, байгууллагын эрхэм зорилго гэсэн хүчин зүйлд сэтгэл ханамжтай байдаг гэсэн хариултыг өгсөн байна.

Ажлын сэтгэл ханамжид нас хамааралгүй, ажилчдын хоорондын харилцаа, орчин, ажил үүргийн тодорхой байдал, үйл ажиллагааны хяналт, цалин олговор хооронд 0.776 буюу хүчтэй хамааралтай. Ажлын байрны орчин, ажлын сэтгэл ханамж хооронд 0.659 цалин хөлс болон нөхөн олговор, ажлын сэтгэл ханамж хооронд 0.625 тус тус хүчтэй хамаарал байна. Нээлттэй асуултын үр дүн болох сэтгэл ханамжид хамт олон, ажлын орчин, харилцаа гэх мэт хүчин зүйлс нөлөө үзүүлдэг гэсэн хариултыг өгсөн нь дээрх таамаглалуудыг батлаж байна.

Ном зүй:

1. Ажлын байрны сэтгэл ханамж индекс Аз жаргал (HAPPINESS) судалгааны хүрээлэн, (2015).
2. Ажилчдын ажлын байрны сэтгэл ханамж болон оролцоо Хүний нөөцийн менежментийн нийгэмлэг (SHRM) (2013).
3. Батхишиг И, (2016). Их, дээд сургуулийн багшийн хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа. Улаанбаатар: Боловсрол судлал.
4. Наранцацрал А, (2016). Ажлын байрны сэтгэл ханамж, түүнд нөлөөлөх хүчин зүйл
5. Наранцэцэг П, (2009). Хүний нөөцийн менежмент, Улаанбаатар
6. Статут Л. (2009). Хүний нөөцийн удирдлага. Улаанбаатар.
7. Увш П. Хэрлэн Б. (2004). Байгууллагын зан үйл. Соёмбо.принтер. ХХК, Улаанбаатар
8. SHRM, (2011). Employee job and satisfaction survey
9. Employee satisfaction survey, <http://www.zarca.com> (2016), <http://www.zarca.com/online-survey-resource/sample-surveys/employee-satisfaction-survey-detailed-version.pdf>